

(З-ДБ-27.1) Хөрөнгийн хуримтлал

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИЙН КОД	ТАЙЛАНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ НЭР	МАЯГТЫН ТӨРӨЛ
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангиллаар	З-ДБ-34	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр	Албан ёсны маягт

(З-ДБ-27)-ийн үргэлжлэл

В. Хөрөнгийн нийт хуримтлал

/мян.төг/

Үзүүлэлт	МД	Дансны үндсэн ангилал	Үнийн дүн (мян.төг)	
			Оны эхэнд	Оны эцэст
А	Б	В	1	2
Үндсэн хөрөнгө <i>мөр68=мөр(69+70+74+79+82+83)</i>	68	20-р дансны холбогдох дүн		
Орон сууцны барилга	69			
Бусад барилга, байгууламж <i>мөр70=мөр(71÷73)</i>	70			
Орон сууцны бус барилга	71			
Бусад байгууламж	72			
Газар, хөрс сайжруулалт	73			
Машин, тоног төхөөрөмж <i>мөр74=мөр(75÷77)</i>	74			
Тээврийн хэрэгсэл	75			
Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж	76			
Бусад машин, тоног төхөөрөмж	77			
Тавилга, эд хогшил	78			
Өсөж үрждэг хөрөнгө <i>мөр79=мөр(80+81)</i>	79			
Мал, амьтад	80			
Олон наст ургамал	81			
Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал	82			
Оюуны өмчийн бүтээгдэхүүн <i>мөр83=мөр(84÷86+89+90)</i>	83			
Судалгаа, шинжилгээний ажил	84			
Геологи хайгуулын ажил болон үнэлгээ	85			
Компьютерийн програм хангамж, мэдээллийн сан <i>мөр86=мөр(87+88)</i>	86			
Компьютерийн програм хангамж	87			
Мэдээллийн сан	88			
Утга зохиол, урлагийн эх бүтээл	89			
Оюуны өмчийн бусад хөрөнгө	90			
Үнэт зүйлс <i>мөр91=мөр(92÷94)</i>	91			
Үнэт металл, чулуу	92			
Эртний эдлэл, гар урлалын бүтээл	93			
Бусад үнэт зүйлс	94			

Заавар: (З-ДБ-27.1) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

В. Хөрөнгийн нийт хуримтлал Үндсэн хөрөнгө (мөр 68) -Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэгээс дээш жил давтан эсвэл үргэлжлэн ашигладаг хөрөнгө бөгөөд үүнд барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, газрын сайжруулалт, үржлийн мал, олон наст ургамал, оюуны өмчийн хөрөнгө багтана. Энд 20-р дансны холбогдох дүнг тавина мөр $68=(69+70+74+79+83)$. Орон сууцны барилга (мөр 69) -Аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг мөн хамруулна. Бусад барилга, байгууламж (мөр 70) -Орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газар, хөрс сайжруулалтаас бүрдэнэ мөр $70=(71+73)$. Машин, тоног төхөөрөмж (мөр 74) -Өрхийн эцсийн хэрэглээнд эзэмшиж байгаагаас бусад тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Харьцангуй бага үнэтэй болон тогтмол худалдан авдаг гар багаж зэргийг машин, тоног төхөөрөмжид оруулахгүй. Түүнчлэн орон сууцны болон орон сууцны бус барилгын бүтцэд хамрагддаг барилгын салшгүй хэсэг болох машин, тоног төхөөрөмжийг мөн оруулахгүй. Цэрэг дайны зориулалтаар худалдан авсан зэр зэвсгийн системээс бусад машин, тоног төхөөрөмжийг энд оруулна мөр $74=(75+77)$. Өсөж үрждэг хөрөнгө (мөр 79) -Байгууллагын шууд хяналт, удирдлагын дор үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, ургамлыг хамруулна. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал (мөр 82) -Газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөц орно. Эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардалд дараах зардал багтана. Үүнд: Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэл; худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал; хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар; хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар; худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал; хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно. Оюуны өмчийн бүтээгдэхүүн (мөр 83) -Биет шинж чанаргүй, хүний оюуны хүчин чармайлтаар бий болдог, нэг буюу түүнээс дээш жил ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг ойлгоно. Үүнд шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, компьютерийн програм хангамж, мэдээллийн сан, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэрэг орно мөр $83=(84+86+89+90)$. Үнэт зүйлсийн хуримтлал (мөр 91) -Үнэт зүйлсийг үнэт металл, чулуу; эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл; бусад гэж ангилна. Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно мөр $91=(92+94)$.

Тайлангийн нэр 3: ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХӨРӨНГИЙН 20... ОНЫ МЭДЭЭ, сургалтын байгууллагаар

Товч нэр: (З-ДБ-28.1) Хөрөнгийн хуримтлал, сургуулиар

Маягтын төрөл: Захиргааны маягт

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлахыг зөвшөөрөх тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/30 тоот тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 05 сарын 27-ны өдөр А/223 тоот тушаал

Зорилго: Дээд боловсролын сургалтын байгууллагын материаллаг эргэлтийн хөрөнгийн мэдээллийг сургалтын байгууллага бүрээр материаллаг эргэлтийн хөрөнгийн төрөл, үндсэн хөрөнгө, үнэт зүйлсийн төрөл бүрээр оны эхэнд, оны эцэст мөнгөн дүнгээр